

Хураангуй зөвлөмж

- Төрийн өмчийн их дээд, мэргэжлийн сургуулиудын зардлын тодорхой хувийг үе шаттайгаар төсвөөс санхүүжүүлэх,
- Газар тариалангийн мэргэжлийг зөвхөн төрөлжсөн их дээд болон мэргэжлийн сургуульд сургадаг тогтолцоог хуульчлах,
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд болон мэргэжлийн сургуулиудыг онцгойлон дэмжих,
- Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангахад оролцдог агроном, агротехник зэрэг мэргэжлийг төсвийн зардлаар сургах,
- Газар тариалангийн салбарын мэргэжлийн боловсрол сургалтын систем маш сайн хөгжсөн улсуудын сайн жишээг судалж хэрэгжүүлэх,
- Хичээлийн анги танхимын номын сан, дадлагын газруудын хүртээмж, нөхцлийг сайжруулах,
- Элсэлтийн нөхцлийг сайжруулан, оюутны тоог нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах,
- Төлбөрийг хөнгөлөх олон сонголттой нөхцлүүдийг хэрэгжүүлэх замаар оюутны тоог нэмэгдүүлэх

Газар тариалангийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудал

Монгол улсад мэргэжилтэй боловсон хүчнийг их дээд сургуулиуд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудад сургаж бэлтгэдэг. Ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 96 дээд боловсролын байгууллага ажиллаж байгаагийн 18.7% нь төрийн өмчийн, 78% нь төрийн бус өмчийн, 3.1% нь гадаадын салбар сургууль, мөн тэдгээрийн 36.4% нь их сургууль, 54.1% нь дээд сургууль, 6.2% нь коллеж байна. Магадлан итгэмжлэгдсэн 67 их, дээд сургуулийн нийт суралцагчдын 84.0 хувь нь бакалавр байгаагаас харахад үндсэндээ бакалаврын сургалтад тулгуурласан үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд 84 мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд буюу политехникум, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд (51 төрийн өмчийн, 33 төрийн өмчийн бус) 39 мянган оюутан 16 салбарын 230 гаруй мэргэжлээр сурч байна. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудыг жилд 20000 гаруй мэргэшсэн ажилчин төгсөж, 60 гаруй хувь нь ажлын байраар хангагдаж байна. Суралцагсдын 28.2% нь аж үйлдвэр, 19.4% нь барилга, 12% нь тээвэр, 7% нь уул уурхай, 5.9% нь үйлчилгээний салбарт, үлдсэн хувь нь бусад салбарт ногдож байгаагаас үзэхэд хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын ажил зогссон дүр зураг ажиглагдаж байна. Мэргэжлийн боловсрол, сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагсдын тоо жил ирэх тусам буурах хандлагатай буюу хүн болгон их, дээд сургуульд суралцах хүсэлтэй болсон хандлага давамгайлж байна.



Газар тариалангийн салбарын мэргэжилтэн, ажилтан бэлтгэж буй сургалтын тогтолцооны өнөөгийн байдал

Газар тариалангийн салбарын дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлыг ХААИС-ийн Агроэкологийн сургууль болон Дархан-уул аймаг дахь ХААИС-ийн харъяа Ургамал Газар Тариалангийн Хүрээлэнгийн (УГТХ) Агроэкологи-бизнесийн сургуульд бакалавр, магистр, докторын шаталсан сургалтын хэлбэрээр явуулж байна. Газар тариалангийн салбарын мэргэжилтнийг дараах хөтөлбөрүүдээр сургаж бэлтгэдэг.

ХААИС-ийн Агроэкологийн сургуульд:

- Агроном
- Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт үнэлгээ
- Хөрс судлал, агрохими
- Газар тариалангаар мэргэшсэн фермерийн аж ахуй
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн менежмент.
- Жимс ногооны агроном

ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь Агроэкологи бизнесийн сургуульд:

- Агроном
- Жимс ногооны агроном
- Хөрс судлал, агрохими
- Агрофермер технологи

Эдгээр мэргэжлийн хөтөлбөрүүдээр 1955 оноос хойш нийт 4502 мэргэжилтэн бэлтгэжээ.

Хүснэгт 1. Газар тариалангийн дээд мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэсэн байдал

№	Мэргэжлийн төрөл	Бэлтгэж эхэлсэн он	Төгссөн мэргэжилтний тоо
ХААИС-ийн Агроэкологийн сургууль			
1	Агроном	1955	2728
2	Жимс ногооны агроном	1963	139
3	Газар тариалангийн үйлдвэрлэлийн менежмент	1997	337
4	Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт үнэлгээ	1997	623
5	Газар тариалангийн мэргэшсэн фермерийн аж ахуй	1999	115
6	Хөрс судлал агрохими	2001	86
ХААИС-ийн УГТХ-ийн Агроэкологи бизнесийн сургууль			
1	Агроном	1993	416
2	Агрофермер технологи		44
3	Хөрс судлал, агрохими		14

Тус салбарт бэлтгэсэн нийт мэргэжилтнүүдийн дийлэнх буюу 69.84%-ийг агроном, 13.83% нь ургамал хамгаалал, хорио цээрийн үнэлгээний мэргэжилтэн эзэлж байна.

Сүүлийн 6 жилийн байдлаар газар тариалангийн мэргэжлийн ангиудад элсэгчдийн тоо эрс багасчээ. Тухайлбал 2014 оноос хойш “Жимс ногооны агроном” мэргэжлээр оюутан элсээгүй байна. Төрийн өмчийн болон төрийн өмчийн бус бүх их дээд сургуулиуд эдийн засгийн хувьд зөвхөн оюутны



төлбөр дээр оршин тогтнодог тул шинээр элсэх оюутны тоо цөөрөх нь сургуулийн тогтвортой үйл ажиллагаанд маш ноцтой нөлөөлдөг.

Дархан-уул аймаг дахь Агроэкологи-бизнесийн сургуулийн хувьд байдал илүү хүнд байна. Тус сургууль хэдийгээр 1500 оюутан сурах багтаамжтай, 300 оюутны дотуур байртай, сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулахад 1400 орчим оюутан суралцах шаардлагатай боловч 2018-2019 оны хичээлийн жилд дөнгөж 700 оюутан суралцсан. Мөн тус сургууль нь Монгол улсад цаг уурч, цаг уурын техникчийн мэргэжилтэн бэлтгэдэг цорын ганц байгууллага боловч сүүлийн жилүүдэд шинээр элсэгчдийн тоо цөөрсөөр байна. Элсэлт буурсан нь нэг талаар ерөнхий боловсролын системийг 12 жилийн сургалтанд шилжүүлснээс шалтгаалж төгсөгчдийн тоо буурсантай холбоотой. Нөгөөтэйгүүр Улаанбаатар хотод суралцах сонирхол давамгайлдаг нь орон нутаг дахь сургуулиудад элсэлт багасахад ихээхэн нөлөөлж байна.

Хүснэгт 2. ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн элсэлтийн тоо

№	Мэргэжил	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020
1	Агроном	40	70	49	26	8
2	Газар тариалангийн үйлдвэрлэлийн менежмент	5	5	9	-	-
3	Хөрс судлал агрохими	-	-	-	7	-
4	Жимс ногооны агроном	-	-	-	-	-
5	Агроном эчнээ 2.5, 4.5	16	25	19	31	16
Нийт дүн		61	100	77	64	24

Газар тариалангийн салбарын мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаа

Газар тариалангийн салбарт мэргэжилтэн бэлтгэхэд их дээд сургуулиудаас гадна мэргэжлийн боловсрол сургалтын төвүүд буюу хуучнаар техник мэргэжлийн сургуулиуд чухал үүрэг гүйцэтгэсэн. 1990-ээд оныг хүртэл Сэлэнгэ, Төв, Архангай, Ховд, Дархан-уул зэрэг аймгийн ХАА-н техник мэргэжлийн сургуулиудад мэргэжлийн агротехник, механикжуулагчид, усалгааны оператор зэрэг мэргэжлүүдээр олон зуун мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэн гаргаж байсан түүхтэй. Гэвч 1990 оноос хойш газар тариалангийн техник мэргэжлийн сургалтын систем доголдсон төдийгүй сангийн аж ахуйнууд задарч хувьчлагдсан зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр газар тариалангийн мэргэшсэн ажилчны эрэлт багассанаар техник мэргэжлийн сургуулиуд татан буугдаж, зарим нь үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж, улмаар энэ төрлийн сургалт бүрэн зогсоход хүрсэн байна. Түүнчлэн төлбөр төлж их дээд сургуулиудад элсэх боломж нэмэгдсэн нь дээд боловсролтой мэргэжилтний тоо эрс нэмэгдэх бас нэг шалтгаан болсон билээ.

Сүүлийн жилүүдэд төрийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд сэргэн хөгжиж байгаа боловч Ховд, Увс, Завхан, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг зарим мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд хүнсний ногооны фермер, ойжуулагч, агротехникч, фермерийн аж ахуй эрхлэгч, хүлэмжийн аж ахуйн фермер зэрг цөөхөн мэргэжлээр сургалт явуулж эхэлж байна.

Газар тариалангийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх хууль эрх зүйн орчин

Тус салбарт “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Төрөөс




боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024 он”, “Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого 2015-2025 он”, “Тариалангийн тухай хууль” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг даган мөрдөж байгаа боловч газар тариалангийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар тусгайлсан эрх зүйн баримт бичиг одоогоор байхгүй. Харин Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх зорилтод Монгол Улсын тэргүүлэх чиглэл болох хөдөө аж ахуй, мал аж ахуй, дэд бүтцийг хөгжүүлнэ гэж тодорхойлсон. Мөн Тариалангийн тухай хуульд, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нь хөдөө аж ахуйн инженер, агрономчтой байх шаардлагатай тухай тодорхой заасан байдаг.


Газар тариалангийн салбарын мэргэжилтэн, ажилтан бэлтгэж буй сургалтын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн дүн шинжилгээ, тулгамдаж байгаа асуудлууд

Газар тариалангийн салбарын дээд боловсролын чанарыг сайжруулах, элсэлтийг нэмэгдүүлэх боломжийг судалж тогтоох зорилгоор Агроэкологийн сургуулийн 1980-2016 оны төгсөгчдийн төлөөлөл 355 хүнээс асуулгын аргаар авсан судалгаанд 15.2% нь тухайн үед агрономын мэргэжил эрэлт ихтэй байсан учраас, 55.5% нь өөрийн сонирхлоор, 17.7% нь бусдын зөвлөгөөгөөр, 8.5% нь дээд боловсрол эзэмших зорилгоор энэ мэргэжлийг сонгосон гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 64.2% мэргэжлээрээ ажиллаж буй бөгөөд мэргэжлээрээ ажиллаагүй 34.9% шалтгааны хувьд 74.2% нь ажлын байр олдоогүй, 8.9% эзэмшсэн мэргэжилдээ сонирхолгүй, 2.4% нь цалин багатай учраас, 3.2% нь мэргэжлийн үр чадвар дутсанаас гэж хариулсан байна. Мөн цаашид сургалтын чанарыг сайжруулахын тулд юуны өмнө онол, практикийн мэдлэгийг тэнцүү олгох (48%) сургалтын орчин, материаллаг баазыг сайжруулах (29%) нь хамгийн чухал байгааг дүгнэсэн байна.

Агроэкологийн сургуулиас 2015, 2016 онд авсан судалгааны дүнгээр газар тариалангийн мэргэжлийн ангиудад элсэхэд нөлөөлсөн хүчин зүйлүүдээс: элсэлтийн шалгалтын оноо 44-45%, элсэлтийн сурталчилгаа, мэдээлэл 16-25%, сургуулийн нэр хүнд 11-17%, санхүүгийн нөхцөл байдал 3-4%, бусад 25-30% тус тус нөлөөлсөн тухай санал асуулгад оролцсон оюутнууд хариулсан байна. Мэргэжлийн багш нарын үр чадварын үнэлгээгээр 88.4% сайн, 22.1% дунд, 3.9% мүү гэж үнэлсэн бол хичээлийн анги танхимын багтаамж, хүрэлцээ, орчин 21.5% сайн, 28.3% дунд, 43.3-50.1% мүү, лабораториуд хичээлийн шаардлагад нийцдэг эсэх 28% сайн, 29.8-32.8% дунд, 36.7-39.3% мүү, мэргэжлийн ном сурах бичгийн хүрэлцээ 23.1-31.4% сайн, 32.1-36% дунд, 32.3-44.8% мүү, номын сангийн үйлчилгээний орчин нөхцөл 29.4-36.3% сайн 29.9-37.5% дунд, 40.6-21.1% мүү хэмээн тус тус үнэлсэн байна.



Тахирмаг 1. Багш нарын үр чадвар



Тахирмаг 2. Хичээлийн танхим хүрэлцээ



Цаашилбал ажил олгогч төрийн болон хувийн хэвшлийн 56 байгууллагаас авсан судалгаагаар 18.7% нь газар тариалангийн дээд мэргэжил эзэмшсэн мэргэжилтнүүдийн үр чадварыг маш сайн, 69.6% нь сайн, 8% дунд, 3.5% нь муу гэж дүгнэсэн байна.

Газар тариалангийн салбарын мэргэжилтэн, ажилтныг бэлтгэхэд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Төрийн бодлогын хүрээнд:

- Төрийн өмчийн их дээд, мэргэжлийн сургуулиудын зардлын тодорхой хувийг үе шаттайгаар төсвөөс санхүүжүүлж тухайн сургуулийг эдийн засгийн хувьд хөл дээрээ бат зогсох боломж олгох,
- Газар тариалангийн салбарын мэргэжилтэнг зөвхөн төрөлжсөн их дээд болон мэргэжлийн сургуульд элсүүлж сургадаг тогтолцоог хуульчлах, өөрөөр хэлбэл дуртай сургуулиуд дурын мэргэжлээр эмх замбараагүй элсэлт авдаггүй болох,
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд болон мэргэжлийн сургуулиудыг онцгойлон дэмжих, зарим ХАА-н мэргэжлийн элсэлтийг Улаанбаатар хотод хязгаарлаж, хөдөө орон нутагт шилжүүлэх,
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй агроном, мал аж ахуй болон хөдөө аж ахуйн инженер зэрэг мэргэжлээр тэтгэлэгтэй сургах,
- Багш нарын цалин хангамж, суралцагсдын тэтгэлгийг нэмэгдүүлэх
- Аж ахуй нэгжүүдээс оюутан дадлагажуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд зарцуулсан хөрөнгө оруулалтыг татвараас хөнгөлөх,
- Газар тариалангийн салбарт мэргэжлийн боловсрол сургалтын систем маш сайн хөгжсөн Герман, Франц гэх мэт орнуудын сайн жишээг суралцаж хэрэгжүүлэх.

Сургалтын байгууллагын анхаарах асуудлууд

- Элсэлтийн нөхцлийг сайжруулан, оюутны тоо нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах, онлайн сургалтыг өргөжүүлэх, стандартыг боловсронгуй болгох
- Хичээлийн анги танхимын хүрэлцээ, орчинг сайжруулах, лабораториудыг орчин үеийн судалгааны багаж, тоног төхөөрөмж, эм үрвалж, зориулалтын өрөөгөөр хангах;
- Практик дадлагын газрууд байгуулах, үйлдвэрлэлд ойрхон нөхцөл бүрдүүлж, оюутны судалгаа шинжилгээний ба үйлдвэрлэлийн дадлага эзэмших боломжийг нэмэгдүүлэх,
- Номын сангийн уншлагын танхим, ном сурах бичгийн хүрэлцээ, чанарыг сайжруулах, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, цахим номын сан байгуулах ажлыг эрчимжүүлэх
- Төлбөрийг хөнгөлөх олон сонголттой нөхцлүүдийг хэрэгжүүлэх замаар оюутны тоог нэмэгдүүлэх
- Сургалт, дадлагыг ургамал ургалтын хугацаанд явуулах нөхцлийг бүрдүүлэх
- Давтан сургалтыг төгсөөд 3-5 жил тутамд зохион байгуулах шаардлагатай бөгөөд кредитийг баталгаажуулсан диплом, үнэмлэх олгох, олгосон үнэмлэх, дипломтой хүн тендер, төсөл, хөтөлбөрт давуу эрхтэй оролцох, хувийн хэвшил төр, захиргааны байгууллагад ажилладаг бол үр чадварын нэмэгдэл олгох,
- Газар тариалангийн мэргэжилтэй холбоотой гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт их сургуулийн багш, оюутнуудад хамрагдах боломжийг бий болгож, нэмэгдүүлэх



Ашигласан зарим хэвлэл

Амаржаргалан.Т, Дээд боловсролын хөгжлийн хандлага, бодлого, чиглэл, “Тогтвортой хөгжил - дээд боловсрол” Улсын хоёрдугаар зөвлөгөөн Улаанбаатар хот, 2018 оны 1 сарын 26-27

Буюнбаатар,А. Газар тариалангийн салбарын хүний нөөцийн хангамж, мэргэжлийн үр чадвар, тулгамдаж буй асуудлууд, 2019 оны 10 сарын 24 өдөр, “Атар 60- Жимс жимсгэнэ судлал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. ХААИС, Улаанбаатар.

Зөвлөмжүүд, "Тогтвортой хөгжил - дээд боловсрол" Улсын хоёрдугаар зөвлөгөөн, Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулсан, Улаанбаатар хот 2018 оны 1 сарын 26-27.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор болох Мэргэжлийн боловсрол сургалтын салбарын багш нарын улсын анхдугаар зөвлөгөөн, /2019.10.03 | Vip76.mn

Уламбаяр,Д. Мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг тогтолцоо тасалдах аюул нүүрлэж байна, 2017 он 08 сарын14, “ Зууны мэдээ” сонин “Leaderships forum”,

VITALII BARBINOV V. N. Korolenko Poltav, VOCATIONAL TRAINING OF FUTURE AGRICULTURAL SPECIALISTS: EUROPEAN EXPERIENCE, 2018, National Pedagogical University, Ukraine
<https://www.researchgate.net/publication/326247587>

Дархан ХААИС хагас зуунд, 2019 он

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогч

Н.Баярсүх, PhD

Ургамал Газар Тариалангийн
Хүрээлэнгийн захирал